

# ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас батлан мөрдүүлж байна. Тус хуулиар Үндэсний баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан болох гурван төрөлжсөн сангаас бүрдэхээр зохицуулсан.

Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөл нь 2 бүлэг, 6 зүйлтэй бөгөөд нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт болон холбогдох хууль тогтоомжуудыг тусгасан бол хоёрдугаар бүлэгт Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, Ирээдүйн өв сан, Хуримтлалын санд хуримтлуулах хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгасан.

## Ирээдүйн өв сан

Газрын хэвлий дэх байгалийн баялгийг ирээдүй үеийн иргэдэд тэгш, шударга хүртээх зорилгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын сан болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгээс Ирээдүйн өв санд хуваарилж, тус санд хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар сангийн үнэ цэнийг өсгөн арвижуулж байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт Ирээдүйн өв сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкна дахь тус сангийн валютын дансанд байршуулахаар заасан бөгөөд 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар санд 1,309.3 сая ам.доллар буюу 4,706.1 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний хуримтлал үүсээд байна.

Ирээдүйн өв санд 2026 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 2,186.9 тэрбум төгрөг, сангийн хөрөнгө оруулалтаас 240.3 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлэхээр тооцлоо.

Түүнчлэн, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад заасны дагуу Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолоор Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын бодлогыг баталсан. Уг бодлогын дагуу Ирээдүйн өв сангийн хөрөнгийг гадаад улсуудын төв банкны хадгаламжид байршуулах гэрээг Монголбанкттай байгуулж, 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар 1,309.0 сая ам.долларын хөрөнгийг Франц, Английн төв банкуудад дунджаар 4.3-4.4 хувийн хүүтэйгээр байршуулаад байна.

Мөн дээрх гэрээний дагуу байгуулсан хадгаламжийн хэлцлийн хүрээнд анх удаа 12.8 сая ам.доллар буюу 45.9 тэрбум төгрөгтэй тэнцэх өгөөжийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Ирээдүйн өв сангийн дансанд төвлөрүүлсэн бөгөөд 2025 оны эцэст сангийн хуримтлал 1,551.9 сая ам.доллар буюу 5,697.7 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Ирэх онд тус сангийн хуримтлалыг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлэхээс гадна сангийн хөрөнгийг гадаад улсын төв банкнуудын хадгаламжид байршуулан нийт 240.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын орлогыг санд төвлөрүүлэхээр тооцлоо.

### **Хуримтлалын сан**

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтад “Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх” гэж тусгасан.

Түүнчлэн, тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.а, 11.1.2.б дэх дэд заалтуудад тус тус зааснаар уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгаас Хуримтлалын санд төвлөрүүлэхээр заасан.

Тус санд 2025 оны 08 дугаар сарын 29-ний байдлаар нийт 654.4 тэрбум төгрөг хуримтлагдаад байгаа бөгөөд 2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр сангийн үлдэгдэл 1,109.1 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Дээр дурдсан хуулийн зохицуулалтын хүрээнд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 2026 онд 372.9 тэрбум төгрөг, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар 156.0 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлэхээр тооцсон.

Засгийн газрын 2024 оны 179, 2025 оны 228 дугаар тогтоолоор Хуримтлалын сангийн хөрөнгийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны хөтөлбөрийг санхүүжүүлэх хэлбэрээр хөрөнгө оруулж, арвижуулахаар шийдвэрлэсний дагуу “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ”-г Монголбанкттай байгуулж, 2024 онд сангийн эх үүсвэрээр 4,158 өрхийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийг санхүүжүүлээд байна.

Мөн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтад заасны дагуу Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолоор “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам”-ыг баталсан бөгөөд уг тогтоолоор Хуримтлалын сангаас зарцуулалт хийх зохицуулалтыг 2030 оноос эхлэх дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн болно.

**Хуулийн төслийн тайлбар /зүйл тус бүрээр/**

**1 ДҮГЭЭР ЗҮЙЛ** –Хуулийн зорилтыг тусгасан.

**2 ДУГААР ЗҮЙЛ** – Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн хууль тогтоомжийн талаар тусгасан.

**3 ДУГААР ЗҮЙЛ** – Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сан бүрд төвлөрүүлэх орлогын хэмжээг тусгасан.

**4 ДҮГЭЭР ЗҮЙЛ** – Ирээдүйн өв сангийн хуримтлалын үлдэгдэл, 2026 онд нэмж хуримтлуулах хэмжээг тусгасан.

**5 ДУГААР ЗҮЙЛ** – Хуримтлалын сангийн хуримтлалын үлдэгдэл, 2026 онд нэмж хуримтлуулах хэмжээг тусгасан.

**6 ДУГААР ЗҮЙЛ** – Хуулийн дагаж мөрдөх хугацааг тусгасан.

---oOo---